



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 31,860,000.00 /гучин нэгэн сая найман зуун жаран мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Ууган-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



000604

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
3.7 дугаар тогтоолын хавсралт

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглагдсан орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Соната-7, 10-23 УБҮ, арал№КМНЕВ41ВАСА.395648	2011/ 2011	103170	31,860,000.00	500,000.00	2,000,000.00
	Нийт дүн			31,860,000.00 /гучин нэгэн сая найман зуун жаран мянган/	500,000.00 /таван зуун мянган/	2,000,000.00 /хоёр сая/